



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

181

2007 оны 01 дугаар
сарын 14-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын Захирагчийн харъяа "Нөөц" компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. "Нөөц" компанийн бүтэц, орон тоо, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын алба Т.Бадамжунай/нд үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 1998 оны А/180 дугаар захирамжийн 1 дүгээр заалтын "Нөөц" компанитай холбогдсон хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны
3.3... Дугаар захирамжийн хавсралт

“ НӨӨЦ “ КОМПАНИ /УУГ/-ИЙ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл.

1.1. Улаанбаатар хотын Захирагчийн харъяа Нөөц компани /цаашид "компани" гэнэ/ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хууль, Нөхөрлөл компанийн хуулийн дагуу байгуулагдсан аж ахуйн тооцоот, нийслэлийн өмчит Улсын Үйлдвэрийн Газар мөн.

1.2. Компани нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Компани нь нийслэлийн захиалгаар үйл ажиллагаагаа явуулж, хийсэн үйлчилгээнийхээ гүйцэтгэлээр хотын төсвөөс санхүүжилт авах бөгөөд хотын үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилсэний зардлаар санхүүжих зарчмаар ажиллана.

1.4. Компани нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.5. Компани нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.6. Компани нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Эсгий, эсгий гутал ХК-ийн зүүн талд байрлана. Утас: 342214.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Компаний захирлыг Ерөнхий менежерийн саналыг харгалзан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж чөлөөлнө.

2.2. Компани нь үйл ажиллагаагаа Улаанбаатар хотын Захирагч, түүний Ажлын албаны удирдлага дор явуулж, ажлаа тайлагнана.

2.3. Компаний дүрмийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч баталж, бүтэц, орон тооны хязгаарт ерөнхий менежер хяналт тавина.

2.4. Компаний захирал нь байгууллагын бүтэц, дотоод журам, орон тоо, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоож мөрдүүлэх ба албан хаагчдыг томилж чөлөөлнө.

2.5. Компаний захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод ашиглаж эзэмшинэ.

2.6. Компаний зорилт, чиг үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх, зөвшилцөх үүрэг бүхий захирлын дэргэдэх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг компаний захирал тушаалаар батална. Зөвлөлийн гишүүд гагцхүү зөвлөх эрхтэй байна.

2.7. Компаний захирлын эрх, үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг Өмчийн газар, үйл ажиллагааны чиглэлээр ерөнхий менежертэй гэрээ байгуулан ажиглана.

Гурав. Компанийн үүрэг

3.1. Компани нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хотын айл өрх, албан газар, үйлдвэр аж ахуйн нэгжийн хог хаягдлыг хүлээж авах, дарж устгах ажлыг боловсронгуй болгох, хотын агаар мандал, байгаль орчныг бохирдлоос хамгаалах талаар тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2. Компани нь хог боловсруулах цэгийг шинээр байгуулах, засварлаж тохижуулах, ашиглалтыг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3. Компани нь төвлөрсөн цэгт хог хүргэж ирж байгаа тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хяналт тавин бүртгэл хийж баталгаажуулж байна.

3.4. Компани нь төвлөрсөн цэгийн орчинд хог хаягдал асгуулж байх хяналтын систем тогтоон хэрэгжүүлнэ.

3.5. Компани нь хотын доторх золбин нохой, муурыг өдөр тутам агнаж нийслэлчүүдийн эрүүл мэнд, амгалан тайван байдлыг хамгаална.

3.6. Компани нь байгууллага, ард иргэдээс ирүүлсэн захиалга, дуудлагаар үйлчилж тэдэнд нохой муураас учруулж болох элдэв сөрөг үр дагаврыг шуурхай барагдуулна.

3.7. Компани нь нийслэлчүүдийн амгалан тайван байдлыг хангах, хотын ногоон бүсийг бохирдлоос хамгаалахад ажлаа чиглүүлж, үйлдвэр үйлчилгээний чанараа байнга дээшлүүлж, компаний ашиг хуримтлалыг арвижуулах, ажилчин албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

3.8. Компани нь үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр байгуулсан гэрээний дагуу байгууллага, иргэдэд түргэн шуурхай чанартай үйлчилж, санал гомдлыг барагдуулах ажлыг зохион байгуулна.

3.9. Компанийн үйл ажиллагааны чиглэлээр гарсан хууль тогтоомж, Нийслэлийн удирдлагын захирамж, шийдвэрийн биелэлтийг хангуулах, гарсан зөрчил дутагдлыг арилгуулж хохирлыг барагдуулна.

3.10. Компани нь хог хаягдал төвлөрүүлж дарж устгах, золбин нохой, муур агнах, үйл ажиллагааны хэтийн бодлого, төлөвлөлттэй холбоотой мэдээлэл, судалгааг бий болгож, сонирхогч гадаад, дотоодын байгууллага, иргэдийг мэдээ мэдээллээр хангана.

3.11. Компани нь байгаль орчин, агаар мандлыг хог хаягдлын бохирдлоос хамгаалахад чиглэгдсэн дотоод гадаадын хөрөнгө оруулалт, хандивлагч орнуудын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн үндэслэл, судалгаа гаргах, төсөл хэрэгжүүлэхэд оролцоно.

3.12. Компани нь хог төвлөрүүлж дарах, золбин нохой муур агнах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудтай чөлөөтэй өрсөлдөх хэмжээнд үйл ажиллагаагаа явуулна.

3.13. Компани нь үйлдвэрлэл үйлчилгээний ажлын үр дүнд олсон ашгаас байгууллагад тогтоож өгсөн хувийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

3.14. Компани нь үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлахдаа төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

3.15. Компани нь нийслэлийн айл, өрх, албан байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийнхуурай хог хаягдлыг хотоос тогтоосон төвлөрсөн хогийн цэгүүдэд ариун цэврийн дэг журмыг сахиулна.

3.16. Компани нь төвлөрсөн цэгүүдэд хогийг ангилан ялгаж, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах.

3.17. Компани нь хотын доторх золбин нохой, муур агнаж мах арьсыг дотоод гадаадын зах зээлд нийлүүлнэ.

3.18. Компани нь үйлдвэрлэл үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэхтэй холбогдсон тоног төхөөрөмж, түүхий эд, сэлбэг, материал олж авах, гадаадаас хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэрлэл оруулж ирэх, хог хаягдлаас байгаль экологид учруулах бохирдлыг багасгах дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

3.19. Компани нь үндсэн чиглэлийнхээ дагуу үйл ажиллагаа явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, машин механизм, түүхий эд, материалын захиалгыг нийслэлийн Захирагчийн ажлын албанд гарган өгч хууль зүйн дагуу шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Компанийн эрх

4.1. Компанийн өмч хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамж болон энэхүү дүрэмд нийцүүлэн эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

4.2. Компаний хариуцах үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлаар гадаад орны болон өөрийн улсын холбогдох байгууллагуудтай харилцах, Улаанбаатар хотын Захирагчийн болон холбогдох эрх бүхий байгууллагын эрх олгосны дагуу гэрээ хэлцэл хийж, хамтран ажиллана.

4.3. Хог хаягдал дарах, нохой муур агнах ажлыг боловсронгуй болгох, шинэ техник технологийг нэвтрүүлэх чиглэлээр төр захиргааны байгууллагаас зохиож байгаа төсөл, хөтөлбөрт оролцох санал дүгнэлтээ тавина.

4.4. Үйлдвэр үйлчилгээ, хөрөнгө оруулалт, урсгал засварын ажилтай холбогдсон машин механизм, тоног төхөөрөмж, түүхий эд сэлбэг материал олж авах, нохойн арьс, мах, тос, хоёрдогч түүхий эдийг гадаад дотоодын зах зээлд гаргах зорилгоор гадаад худалдаа эрхлэнэ.

4.5. Компаний ажлын үр дүнгээр ажиллагсадад нэмэгдэл хөлс олгох, шагнаж урамшуулах, амьдрал ахуйд нь туслаж дэмжих асуудлыг шийдвэрлэнэ.

4.6. Байгууллагын хөдөлмөрийн болон ажил мэргэжлийн аваргаа шалгаруулж, алдаршуулна.

Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

5.1. Компаний эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, тайланг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.

5.2. Компаний санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь газар байгуулагдсан өдрөөс эхэлж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь газрыг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

5.3. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

5.4. Компани нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.5. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.6. Компаний санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.7. Компаний удирдлага нь газрын үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.8. Компаний тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

5.9. Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах болон худалдах, хувьчлахдаа төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журмыг баримтлана.

Зургаа. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах

6.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн санал болгосноор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, газрыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

6.2 Компанийг татан буулгах тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс уг ажлыг эрхэлнэ.

6.3 Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан тэнцэл гаргуулан, үүсгэн байгуулагчид танилцуулж, нийтэд мэдээлж, өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу төлөгдсөний дараа үлдсэн хөрөнгийг 3 сарын дотор үүсгэн байгуулагчид шилжүүлнэ.

Долоо. Хариуцлага

7.1. Компаний албан хаагчид нь байгууллагын дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

7.2. Монгол улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамж, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.3. Компаний захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагадаа хохирол учруулсан бол уг хохиролыг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцна.

Найм. Бусад

8.1 Энэхүү дүрмэнд нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2 Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.